



АРХАНГАЙ АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

АРХАНГАЙ АЙМГИЙН ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙН БАЙДЛЫН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

2018/05



www.nso.mn www.arkhangai.nso.mn www.1212.mn




ЭРҮҮЛ МЭНД

Эмнэлгийн байгууллагууд 519 ор, амбулаторийн 99 их эмчтэйгээр хүн амд үйлчилж давхардсан тоогоор 145.0 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсний 57.2 мянгад нь урьдчилан сэргийлэх үзлэг хийж 9.0 мянган хүнийг эмнэлэгт хэвтүүлэн эмчилж гаргасан байна.

Вакцинжуулалтанд хамрагдвал зохих 0-2 насны хүүхдийн 98.8 хувийг бүрэн хамруулсны дотор Жаргалант, Цэцэрлэг, Хайрхан, Цэнхэр сумд 100.0 хувь хамруулсан байна.


Амаржсан эх, амьд төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн эхний 5 сарын байдлаар



Оны эхний 5 сард 688 эх төрж, 691 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 5.2 хувиар буюу 38 хүүхдээр бага байна.

Хүн амын нас баралт 221 гарсан нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 2 тохиолдлоор буюу 1 хувиар бага байна. Мянган хүнд ноогдох төрөлт 7.2, нас баралт 2.3 ноогдож хүн амын ердийн цэвэр өсөлт 4.9 промил байна. Төрөхийн улмаас

эндсэн эхийн эндэгдэл 1 гарч, 1-5 насны хүүхдийн эндэгдэл 3, нялхсын буюу 0-1 насны хүүхдийн нас баралт 10 гарч мянган амьд төрөлтөд 14 ногдож байна.



Аймгийн дүнгээр арван мянган хүн тутмаас 23 нь буюу 224 хүн халдварт өвчнөөр өвчилсөн байгаа бөгөөд Тариат(24), Эрдэнэбулган(49), Цэнхэр (25), Булган (25) сумдад аймгийн дунджаас дээгүүр бусад сумдад аймгийн дунджаас доогуур байна. Халдварт өвчнөөр өвчлөгсдийн 12.9 хувь нь салхин цэцгээр, 51.3 хувь нь бэлгийн замын халдварт өвчнөөр, 7.6 хувь нь сүрьеэгээр, 19.6 хувь нь цусан суулгаар, 8.6 хувь нь бусад халдварт өвчнөөр өвчилсөн байна. Халдварт өвчний гаралт өнгөрсөн оны мөн үеэтэй ижил түвшинд гарсан байна.



АЖИЛГҮЙДЭЛ, АЖЛЫН БАЙР


6 дугаар сарын 1-ний байдлаар хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй ажил идэвхтэй хайж байгаа 1270 ажилгүй хүн байгаагийн 48.7 хувь нь буюу 619 нь эмэгтэйчүүд байна. Хөдөлмөрийн насны 10.0 мянган хүн тутамд 217 ажилгүйчүүд

ноогдож байгаа бөгөөд өнгөрсөн оны мөн үеийнхээс бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 3.9 хувиар буурсан байна. Бүртгэлтэй ажилгүйчүүдийн 99.0 хувь нь боловсролтой иргэд байгаагийн 194 нь дээд, 64 нь тусгай дунд болон мэргэжлийн анхан шатны, 945 нь бүрэн болон бүрэн бус дунд, 54 нь бага боловсролтой хүмүүс байна.

5 дугаар сард ажилгүйчүүдийн бүртгэлд 211 хүн шинээр бүртгүүлж, 14 хүн ажил идэвхитэй хайхаа больсноос идэвхигүй болж 165 хүн ажилд зуучлуулан орсон байна.

Оны эхний 5 сард аймгийн дүнгээр 240 ажлын байр шинээр бий болгосон байна. Шинэ ажлын байрыг сумдаар үзвэл Эрдэнэбулган сум 71, Өндөрүлаан сум 50, Чулуут, Хотонт сум 24-23, Батцэнгэл, Жаргалант, Цэцэрлэг, Эрдэнэмандал, Булган, Хашаат, Хангай, Хайрхан, Цэнхэр, Өлзийт, Өгийнуур, Тариат, сумд 8-5 ажлын байр, Цахир, Төвшрүүлэх сум 2 - 1 ажлын байрыг бий болгожээ.

Ажлын шинэ байранд ажилд орсон иргэний тоо






НИЙГМИЙН ДААТГАЛ ХАЛАМЖ

Нийгмийн даатгалын сангийн орлого оны эхний 5 сард 24.9 тэрбум төг, зарлага 23.7 тэрбум төг болж өмнөх оныхоос орлого 3734.7 сая төг буюу 17.7 хувиар, зарлага 3009 сая төг буюу 14.6 хувиар өслөө.

Нийгмийн даатгалын сангийн орлого өмнөх оныхоос 3734.7 сая төгрөгөөр өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн орлого 17.6 хувиар, эрүүл мэндийн даатгалын сан 28.5 ҮОМШӨ-ний даатгалын сан 36.7 хувиар тус тус өссөн нь нөлөөлсөн байна.

Нийгмийн халамжийн сангаас олгосон мөнгөний 57.3 хувийг халамжийн тэтгэврээр, 32.8 хувийг нөхцөлт мөнгөн тэтгэмжээр, 9.9 хувийг ахмад настан хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд олгосон болон хүнс тэжээлийн хөнгөлөлт тусламжид зарцуулж байна.

Нийгмийн халамжийн сангаас олгосон, тэтгэвэр, тэтгэмжийн бүтэц



Нийгмийн даатгалын сангийн зарлага өмнөх оныхоос 14.6 хувиар өсөхөд тэтгэврийн даатгалын сан 14.9 хувиар,

эрүүл мэндийн даатгалын сан 15.5 хувиар, ҮОМШӨ-ний даатгалын сан 34.4 хувиар өссөн нь нөлөөлөв. Тэтгэврийн даатгалын сангаас тэтгэвэрт 13.2 мянган хүнд 21.2 тэрбум төгрөг, тэтгэмжийн даатгалын сангаас бүх төрлийн тэтгэмжид 1248 хүнд 786.5 сая төгрөгийг олгосон байна.


Оны эхний 5 сард нийгмийн халамжийн сан болон хүний хөгжил сангаас давхардсан тоогоор 36.6 мянган хүнд 6252.8 сая төгрөгийн тэтгэмж хөнгөлөлт тусламж, хишиг олгосон байна. Нийгмийн халамж үйлчилгээгээр олгосон нийт мөнгөний 48.9 хувь нь нийгмийн халамжийн сангаас олгосон халамжийн тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж, хөнгөлөлт, 51.1 хувийг улсын төсвөөс олгосон тэтгэмж тусламж эзэлж байна.



ГЭМТ ХЭРЭГ

Аймгийн хэмжээгээр 109 хүн гэмт хэрэгт холбогдож 266 гэмт хэрэг гарсны дотор хүний амь бие эрүүл мэндийн эсрэг хэрэг 75, өмчлөх эрхийн эсрэг 146, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг 14, байгаль хамгаалах журмын эсрэг 3, бусад 28 хэрэг гарсан байна.

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, гэмт хэрэгт холбогдогчийн тоо, жил бүрийн эхний 5 сарын байдлаар



Гэмт хэргийн улмаас 11 хүн нас барж, 79 хүн гэмтэж бэртэн улс болон иргэдэд 146.9 сая төгрөгийн хохирол учирсан байна. Бүртгэгдсэн нийт хэргийн 8.6 хувийг бүлэглэж 11.3 хувийг согтуугаар үйлдсэн байгаа ба зөрчил гаргасан 336 хүнийг албадан саатуулж 149 хүнийг баривчилсан байна.

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо, жил бүрийн эхний 5 сарын байдлаар



Өнгөрсөн оны мөн үетэй зэрэгцүүлэхэд бүртгэгдсэн гэмт хэргийн тоо 6.4 хувиар буюу 16 тохиолдлоор өссөний дотор тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 16.7 хувиар буюу 2 тохиолдлоор, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 14.4 хувиар буюу 20 тохиолдлоор тус тус өссөн байна.




ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ОРЛОГО ЗАРЛАГА

Улсын төвлөрсөн төсвийн шилжүүлэг дэмжлэгийг оруулан тооцсоноор 2019 оны эхний 5 сард аймгийн төсөвт 6982.1 сая төгрөгийн орлого төвлөрүүлэхээс 8191.0 сая төгрөгийн орлого оруулж төлөвлөгөөг 117.3 хувиар биелүүлсэн байна. Улсын төсвийн шилжүүлэг дэмжлэгийг

оруулахгүйгээр аймаг өөрөө 2517.1 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээс 2992 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлэн төлөвлөгөөг 139 хувиар биелүүллээ. Төсвийн орлогын төлөвлөгөөг Батцэнгэл, Чулуут, Хотонт, Жаргалант, Цахир, Цэцэрлэгээс бусад сумд 107.9 хувиас 5.9 дахин биелүүлсэн байна.

Орон нутгийн төсвийн орлогын бүтэц, хувиар



Орлогыг нэр төрлөөр нь үзвэл үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого, ус рашааны төлбөр, газрын төлбөрөөс бусад нэрийн орлогуудыг 113.8 хувиас 3.3 дахин биелүүлсэн байна.


Аймгийн төсвийн орлогын 54.5 хувийг тусламжийн орлогоор, 27 хувийг орлогын албан татвараар, 1.3 хувийг өмчийн татвараар, 3.7 хувийг тусгай зориулалтын орлогоор /АТӨЯХэрэгслийн/, 4.5 хувийг бусад албан татвараар, 7.2 хувийг татварын бус орлогоор, 1.7 хувийг хөрөнгийн орлогоор бүрдүүлж байна.

Улсын төвлөрсөн төсөвт аж ахуй нэгжийн орлогын татвараар 105.6 сая төгрөг, нэмэгдсэн өртгийн албан татвараар 342.0 сая төгрөг, агаарын бохирдлын төлбөрөөр

21.0 сая төгрөг бүгд 468.6 сая төгрөгийг шилжүүлж даалгаврыг 129.4 хувиар давуулан биелүүллээ.

Орон нутгийн төсвийн байгууллагуудын зарлагын хэмжээ 25764.0 сая төгрөг байгаагийн 61.1 хувийг цалин хөлсөнд, 7.7 хувийг нийгмийн даатгалын шимтгэлд, 31.2 хувийг бараа үйлчилгээ болон бусад зардалд зарцуулжээ. Эдийн засгийн салбараар харвал 24.0 хувийг орон нутгийн засаг захиргаанд, 63.1 хувийг боловсролын салбарт, 11.5 хувийг эрүүл мэндийн салбарт, 0.8 хувийг барилга хот байгуулалтын салбарт, 0.6 хувийг бусад салбарт зарцууллаа.

Орон нутгийн төсвийн байгууллагын
нийт зарлагын бүтэц, хувиар




МӨНГӨ ЗЭЭЛ, ХАДГАЛАМЖ

Манай аймагт арилжааны 4 банкны салбар иргэд аж ахуй нэгж байгууллагуудад үйлчилгээ үзүүлж байна. Монгол банкны мэдээгээр арилжааны банкууд монгол банкнаас

зузаатгалаар 17.1 тэрбум төгрөгийг авч 18.8 тэрбум төгрөгийг гүйлгээнээс эргүүлэн татсан байна.

Оны эхний 5 сард банкууд 25.8 мянган иргэд, аж ахуй нэгжид 55.7 тэрбум төгрөгийн зээл олгосон байна.

Иргэдийн хадгаламжийн үлдэгдэл, олгосон зээлийн хэмжээ, жил бүрийн эхний 5 сарын байдлаар сая.төг



Өнгөрсөн оны мөн үеийнхтэй зэрэгцүүлэхэд иргэдийн хадгаламжийн үлдэгдэл 28.8 хувиар өсч, олгосон зээлийн хэмжээ 7.6 хувиар буурсан байна. Харин анхаарал хандуулах зээлийн хэмжээ 21.1 хувиар буурч, чанаргүй зээлийн хэмжээ 20.9 хувиар нэмэгдсэн байна.



ХЭРЭГЛЭЭНИЙ ҮНЭ

2019 оны 5 дугаар сард бараа үйлчилгээний үнэ тариф өмнөх сарынхаас 1.7 хувиар, өнгөрсөн оны мөн үеийнхээс 8.3 хувиар, 2018 оны 12-р сарынхаас 3.9 хувиар тус тус өссөн байна.

Өнгөрсөн 4 дүгээр сартай зэрэгцүүлэхэд хэрэглээний сагсанд авсан 238 нэрийн бараа үйлчилгээний үнэ тарифын 14.7 хувийнх нь өсч, 7.1 хувийнх нь үнэ буурч 78.2 хувийнх нь үнэ тогтвортой байлаа. Тухайлбал өмнөх сарынхаас сүү, аарц, өөхөн тос, хорхой ааруул, савласан сүү, алим, тамхи, эдийн саван зэргийн үнэ 0.1 - 10.6 хувиар буурч харин адуу, хонь, ямаа, үхрийн мах, бензийн

шатахууны үнэ, гурил, шар будаа, пиво, сахлын татуурга, унадаг дугуй, даралтны эм, гар нүүрийн саван зэргийн үнэ 0.5 – 34.2 хувиар нэмэгдсэн байна,

Харин өмнөх оны мөн үетэй зэрэгцүүлэхэд 20.1 хувийнх нь буюу 48 нэрийн бараа үйлчилгээний үнэ буурч, 49.6 хувийнх нь буюу 118 нэрийн бараа үйлчилгээний үнэ тариф өсч, 30.3 хувийнх нь үнэ тогтвортой байна.


Өнгөрсөн оны мөн үеийнхээс дотор мах, манжин, лууван, цагаан будаа, түлээний мод, лаа, тамхи, оймс, жинсэн өмд зэргийн үнэ 0.1 – 56.4 хувиар буурч харин үхэр адууны мах, тараг, шар тос, өндөг, аарц, амтлагч, алим, эрэгтэй эмэгтэй хүний гадуур, дотуур хувцас, гутал, ботинк, саван, хадаас, мотоцикл, бүх төрлийн шатахуун зэрэг барааны үнэ 0.6 – 75.0 хувиар нэмэгдсэн байна.



ХӨДӨӨ АЖ АХУЙ

6 дугаар сарын 1-ний байдлаар оны эхний хээлтэгч малын 81.2 хувь нь буюу 1921.5 мянган эх мал төллөж гарсан төлийн 97.8 хувь нь буюу 1878.6 мянган төл бойжиж байна. Төл бойжилтыг малын төрлөөр үзвэл гарсан ботгоны 100.0 хувь, унаганы 96.8 хувь, тугалын 97.8 хувь хурганы 98.3 хувь, ишигний 96.8 хувь нь бойжиж байна.


Төл бойжилтын хувь



Сумдаас Төвшрүүлэх, Өгийнуур сумд төлийн хорогдол гараагүй бол Жаргалант, Хотонт сумд гарсан төлөө 93.0 – 94.1 хувиар бойжуулж байна. Өнгөрсөн оны мөн үеийнхээс аймгийн дүнгээр төллөсөн эх мал 4.6 хувиар, бойжиж байгаа төлийн тоо 16.2 хувиар их, төлийн хорогдол 54.7 хувиар бага байна.

Эхний 5 сарын байдлаар оны эхний мал 99.4 хувиар онд орж оны эхний малын 0.6 хувь буюу 33.2 мянган том мал хорогдов. Хорогдсон малын 7.2 хувийг адуу, 10.2 хувийг үхэр, 51.7 хувийг хонь, 30.9 хувийг ямааны хорогдол эзэлж байна.

Зүй бусаар хорогдсон малын тоо бүтэц, төрлөөр



Сумдаас Ихтамир, Жаргалант, Эрдэнэмандал, Хайрхан, Цахир, Цэнхэр сумдын оны эхний малын 0.8 – 1.2 хувь нь, Эрдэнэбулган, Булган, Тариат, Батцэнгэл, Хангай, Цэцэрлэг, Өлзийт сумдын оны эхний малын 0.4 – 0.6 хувь нь, Өгийнуур, Төвшрүүлэх, Хотонт сумдын оны эхний малаас хорогдол гараагүй байна.

Хаврын тариалалтын ажил ид явагдаж одоогоор 8705 га-д үр тариа, 178.5 га-д төмс, 59.9 га-д хүнсний ногоо, 199.9 га-д

малын тэжээлийн ургамал, 100 га-д техникийн ургамал тус тус тариалаад байна.

Өнгөрсөн оны энэ үеийнхтэй зэрэгцүүлэхэд үр тариа 33.7 хувиар, төмс 51.1 хувиар, хүнсний ногоо 24.4 хувиар, их тариалсан бол техникийн ургамал 2.5 дахин, тэжээлийн ургамал 18.2 хувиар бага тариалсан байна.

2019 онд манай аймаг ойгоос 93.2 мянган м3 галын түлээ, 10.6 мянган м3 хэрэгцээний мод, бүгд 103.8 мянган м3 мод авч ашиглахаар баталсанаас оны эхний 5 сард 35.8 мянган м3 галын түлээ, 4.9 мянган м3 хэрэгцээний мод, бүгд 40.7 мянган м3 мод бэлтгэж хэрэглэсэн байна. Бэлтгэсэн модны гоожингийн орлогоор 119.7 сая төгрөг төсвийн орлогод оруулсан байна.



АЖ ҮЙЛДВЭР


Үйлдвэрийн газрууд 2019 оны эхний 5 сард оны үнээр 3063.7 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж 2999.8 сая төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан нь өнгөрсөн оныхоос үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн 1.8 хувиар илүү бол борлуулсан бүтээгдэхүүн 0.2 хувиар бага байна. Зэрэгцүүлэх үнээр үнэлснээр 1062.5 сая төгрөгийн нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 3.7 хувиар их байна.

Нийт үйлдвэрлэлтийн 8.8 хувийг хүнс ундааны, 1.2 хувийг хэвлэлийн, 67.5 хувийг дулааны эрчим хүчний, 11.6 хувийг усан хангамж, 3.0 хувийг модон эдлэлийн, 6.8 хувийг гутал хувцасны, 1.1 хувийг бусад үйлдвэрлэл эзэлж байна.

Гол нэрийн бүтээгдэхүүнээс талх, нарийн боов, хэрчсэн гурил, дулаан, хүснэгт маягт, эмээлийн мод, зүсмэл, эсгий шаахай, монгол гутлын үйлдвэрлэл 1.6 –101.6 хувиар нэмэгдлээ. Харин зүсмэл, гэрийн мод, түгээсэн цэвэр ус,

савласан цэвэр усны үйлдвэрлэлийн хэмжээ 14.3 – 51.4 хувиар буурсан байна.

Аж үйлдвэрийн нийт үйлдвэрлэлт, бүтэц, хувиар



Тээврийн байгууллагууд 18.7 мянган зорчигч, 6.4 мянган тонн ачаа тээвэрлэн 8.7 сая хүн км, 2.6 сая ткм ажил гүйцэтгэн 308.7 сая төгрөгийн орлоготой ажиллаа. Өнгөрсөн оны мөн үеийнхээс зорчигч, зорчигч эргэлт 13.6-13.8 хувиар буурч, ачаа, эргэлтийн хэмжээ 27.3 - 59.1 хувиар нэмэгдсэн байна.

Холбооны байгууллагууд 391 телефон цэг улс, хот хоорондын телефон, интернет, телевизийн үйлчилгээгээр байгууллага иргэдэд үйлчилж сумдад 7 хоногт 1-2 удаа шуудан хүргэж нийт 139.0 сая төгрөгийн орлоготой ажилласан нь өнгөрсөн оны мөн үеийнхээс 29.6 хувиар нэмэгдсэн байна.



ЦАГ УУРЫН БАЙДАЛ

5 дугаар сард агаарын дундаж температур 4.6-аас 11.2 хэм байсан бөгөөд хамгийн их дулаан Хашаат, Хайрхан сумдад

29.0 – 30.0 хэм хүрч байсан бол хамгийн хүйтэн нь Өндөрүлаан, Чулуут, Булган сумдад –10.0-аас –15.0 хэмд хүрч хүйтэрч байсан байна.

Оны эхний 5 сарын байдлаар Эрдэнэбулган, Булган, Батцэнгэл, Төвшрүүлэх сумдын нутгаар 41.5 - 58.2 мм хур тундас орсон нь хамгийн их байгаа бол Хайрхан, Өгийнуур, Цахир сумдад 4.8 – 10.8 мм хур тундас орсон нь хамгийн бага байна.

Статистикийн хэлтэс
2019.06.14